Ажлын талбайн ерөнхий зүйл

(1) Онцгой чухал аюулгүйн тэмдгүүд

Хол бай

* Аюултай газар учраас ийшээ бүү нэвтэр!

Нүхнээс болгоомжил

* Том онгорхой байгаа учраас битгий уначихаарай!
* Тэр онгорхой руу нуруугаа бүү харуул!

Толгойгоо анхаар

* Дээрээс юм унаж болзошгүй!
* Таны толгойг цохиж магадгүй!

Алхаагаа анхаар

* Алхаа гишгээгээ анхаар, бүдрэхээс болгоомжил!
* Материал дээр гишгэснээр доошоо унадаг!

Хүнийг унахаас хамгаалах систем

*Та Хүнийг унахаас хамгаалах системийг заавал ашигла

Тогонд цохиулах

* Тогонд цохиулах эрсдэлтэй! Болгоомжтой байгаарай!
* Газардуулга бас шаардлагатай мэх мэт баталгаажуулалт!

出典：建設業労働災害防止協会
Japan Construction Occupational Safety and Helth Association

(2) Хүнийг унахаас хамгаалах системийн (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) хэрэглээний тухай

Хүнийг унахаас хамгаалах системийг (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) 2 м юмуу түүнээс илүү өндөрт ашигласан эсэхийг нягтал!



Унасан үед цохилтоос шалтгаалж ажилчин ясны цууралт авдаг.



2 м юмуу түүнээс илүү өндөрт Хүнийг унахаас хамгаалах системийг (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) хэрэглэцгээе

Энэ бол таны үүрэг!!

Хүнийг унахаас хамгаалах системийг (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) бэлхүүсээс дээш дэгээдэх ёстой.

Хүнийг унахаас хамгаалах иж бүрэн системийг (унахаас сэргийлсэн иж бүрэн бэхэлгээ уяа) зөв зүүх

Сулыг шалга!→



(3) Хүнд жинтэй урт зүйлийг зөөвөрлөх

Хүчитгэсэн ган арматурын голч нь том байдаг учраас хүнд осол гаргадаг тулд анхаарал хандуулах шаардлагатай!

* Багахан хатгалт ч хурууг өлхөн гэмтээнэ.



Гэмтлүүд нь голдуу урт зүйлээс шалтгаалдаг!

* Хүчитгэсэн ган арматур таны орчинд байгаа хүмүүсийг гэмтээнэ.



* Заримдаа ажилчид хоёр хүнтэйгээр хүчитгэсэн ган арматурыг авчирснаар үлдэгдэлгүй болдог.



Харилцан нэг нэгийгээ дуудаж материалыг өргөж намсгах цагийг тохируулаарай.

(4) Онгорхойн төгсгөлд, түүний орчинд ажиллах тухай

* Ирмэг юмуу онгорхой орчинд ажиллах үед Хүнийг унахаас хамгаалах системийг (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) хэрэглэсэн эсэхийг нягтал!

* Ирмэг юмуу онгорхой руу нуруугаа бүү харуул!

(5) Цахилгаан багажийг зөв ашиглах

Цахилгаан таслагч ба цахилгаан нугалагч машиныг зөв ашиглах

* Хүчитгэсэн ган арматурыг бүрэн таслахаас өмнө хуруугаа авдаг олон ослууд байдаг.



* Арьсан бээлий нугалах цахилгаан машинд хавчигдсан олон осол гардаг!

(6) Бүдэрч унахаас шалтгаалсан ослуудын тухай

Унах нь нисэж байгаа унадаг зүйлийн дэргэд хамгийн том хоёрдахь нийтлэг осол юм! Хөлөө болгоомжтой анхааараарай!

* Шат юмуу ямар нэгэн юманд бүдэрч гараа хугаласан олон тохиолдол байдаг учраас болгоомжтой бай!

* Хүчитгэсэн ган арматур өнхөрч ажилчин унадаг олон осол байдаг. Материалыг тодорхой газар хадгална!

(7) Янз бүрийн хурц зүйлийн тухай

Барилгын талбай дээр янз бүрийн хурц үзүүртэй зүйлүүд байдгийг дахин баталгаажуул. Хүчитгэсэн ган арматурын хэлтэрхий хүнд гэмтэл учруулсан олон жишээ байдаг!

* Тавцангийн самбарын ирмэг ба арматурын төмөртэй тулгуур тавцан зэрэг олон хурц зүйлээс болгоомжил!
* Дамнуур хэсгийн доод талд унасан зүйлийг авах үедээ гараа хавчуулж гэмтсэн олон тохиолдол байдаг.



* Дам нурууны хүчитгэсэн ган арматурын доод хэсгийг зангидах юмуу дам нурууны үндсэн арматурыг зангидах үед гараа оруулах үед олон осол болдог учраас болгоомжтой байгаарай!

(8) Барилгын талбайд гэмтэхээс зайлсхийхийн тулд (хураангуй)

- Нэвтрэх ёсгүй эсвэл дамжих ёсгүй газруудыг санаж байх!
- 2 м юмуу түүнээс илүү өндөрт Хүнийг унахаас хамгаалах системийг (унахаас сэргийлсэн бэхэлгээ уяа) хэрэглэх!
- Том голчтой хүчитгэсэн ган арматураас шалтгаалсан олон осол гардаг учраас тэдгээртэй харьцахтай туйлын болгоомжтой байх!
- Урт зүйлээс шалтгаалсан олон ослууд гардаг учраас өөртөө ачаалал өгөлгүйгээр тохирсон жин ба хүний тоог тохируулаарай.
- Барилгын ажил явагдаж байгаа (үзүүр) ыба онгорхой зэрэгт унах олон ослууд байдаг!
- Цахилгаан багажаас шалтгаалсан олон осол гардаг учраас тэдгээртэй харьцахтай туйлын болгоомжтой байх!
- Барилгын талбайд хальтиргаатай учраас алхахад хэцүү байдаг. Энэ маш аюултай газар гэдгийг өөртөө сануулах!
- Барилгын талбайд олон хурц зүйлүүд байдаг учраас үрэх, үсрэх, цохихгүй байх анхаар!

Барилгын талбайд ажиллаж байхдаа аюултай газарт ажиллаж байгаагаа мартаж орчиндоо амархан уусдаг. Та аюултай ойр байдаг гэдгээ байнга санаарай.